

I. Монголын дундат үеийн түүхийн асуудлууд

МОНГОЛЫН ЭРТ, ЭДҮГЭЭГИЙН НУТАГ ГАЗАР

Б.Буянчуулган¹

Монгол болбоос эдүгээгээс өмнө 5 мянган жил орчим Энэтхэгийн орноос умар зүгт нүүдэллэж Ази тивийн дундад газар оронд хүрч ирээд Хуань хэ хэмээх Шар мөрөн буюу Хатаны голын III муруйгаас эхлэн IX муруй хүртэл түмэн газрын урт хэдэн мянган газрын өргөн усны савын газар орныг эзлэн суусан агсан ажгуу. Хатаны голын хэмээгч Ази тивийн баруун Хянганы цаст цагаан уулын дэлгэсэн одон мэт олон булгаас үүсч гарсан нь зүүн Хянганд Номлон Дөлгөөн их далайд ормой.

Монголчууд эрт 46,33 оны үест сая ураг төрлөөр аймаг сав болж тогтнон суусан болох нь түүхэнд тэмдэглэгдсэн анхны үе бөгөөд энэхүү газар оронд оршин суусан амой.

Тэр цагт тэмдэглэгдсэн түүхэнд эдгээр газар оронд оршин суусан олон нүүдлийн аймгийг Жун, Ди, Ну хэмээх зэргээр нэрийдэж чухам үндэс угсааг ялган чадаагүй мэт боловч үүний дотор Монгол бүхий нь сэжиггүй үнэн, тэр дээр хожмын үед Ази тивийн өмнө этгээдэд суусныг Мэн хэмээн нэрлэж Энэтхэг хэмээн таньжээ. Баруун этгээдэд хүн хэмээн нэрийдэж Түвэд, Тангуд, Хотон гэж Таньжухуй, Умарт этгээдэд суусныг Ху хэмээн нэрлэж Монгол, Татар, Зөрчид хэмээн таньжухуй.

Үүнд хамгийн тэргүүнд улсын нэр оны цолтой тусгай улс төрийг байгуулж, олон улсад батлагдсан нь Жу улсын эзэн хаан нь Ху хэмээх Монгол болмой. Бас дараагаар эдгээр олон аймгийг нэгтгэж хүчирхэг Их улсыг анх байгуулж, бүх дэлхийд алдаршсан Хүннү улсын эзэн хаан нь Ху хэмээх монгол болохын тулд

¹ Ахмад түүхч Бүрд Бавуучинбуу Буянчуулган /1885-1937/ нь чахар Шулуун шар хошуунд төрсөн бөгөөд 1911 онд Монгол даяар үндэсний эрх чөлөөний хувьсгал өрнөж Ар Монголоос Чин улсын захиргааг хөөн зайлуулж тусгаар тогтнолоо тунхаглах үеэр Ар Монголд хүрэлцэн ирж тусгаар тогтносон, Олноо Өргөгдсөн Монгол Улсыг батлан хамгаалах үйл хэрэгт оролцож төрийн яаманд бичээч, түшмэл, орчуулагч зэрэг алба хашиж байсан. Тэрбээр 1921 онд үндэсний ардчилсан хувьсгалд оролцож, идэвхтэй хүчин зүтгэсэн учраас 1925-1929 онд ЗХУ-д БНМАУ-ын элчин сайдаар томилогдон ажиллаад дараа нь Гадаад явдлын яаманд хэлтсийн эрхэлсэн түшмэл, Шинжлэх Ухааны Хүрээлэнд архивын эрхлэгч, түүхийн тасгийн эрхлэгч, хүрээлэнгийн гишүүнээр ажиллаж байжээ. Тэрбээр "Чахарын мал аж ахуйн тухай тэмдэглэл", "Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлсэн хэрэглэгдэхүүн", "Дөрвөн Ойрадын түүх" зэрэг зохиолууд бичсэн.

БНМАУ-д 30-аад оны сүүлээр явагдсан зүүний нугалаа завхарлын үед нэрт түүхч, дипломатч, Бүрдийн Буянчуулган хилс хэргээр цаазлуулсныг 1989 онд БНМАУ-ын Дээд шүүхийн коллегийн хурлаар цагаатгасан юм.

Хүннү улсын үед харъяат бүх аймаг Лин Ху хэмээх Баруун монгол, Дун Ху хэмээх Зүүн Монгол хэмээн цом монголын нэрээр дуудах бүлгээ.

Тэр үед Хуань хэ хэмээхийн Хатаны голын зүүнээ урссан III муруйн хойд этгээд Хөх нуур, Ирхайн хязгаар, Хатаны голын өмнө зүг орсон IV муруйн баруун этгээдийг Хэ си хэмээх баруун муж, зүүн этгээдийг Хэ дун хэмээх зүүн муж, Хатаны голын зүүн зүг урссан V муруйн хойд этгээдийг Хэ Бэй хэмээх хойд муж, өмнө этгээдийг Хэ нань хэмээх өмнө муж, Хатаны голын умард зүг урссан VI муруйн зүүн этгээдийг Ляодун муж, баруун этгээдийг Ляоси хэмээх баруун мужийн зэрэг газрууд нь эртний Монголын нутаглан суусан орон нутаг болмой.

Хүннү Улсаас эхлэн уламжилж ирсэн Монголын олон улсаас эртний газар орныг Нанхиадын зэрэг гадаад улсуудад удаа дараагаар алдагдан эзлэгдсээр Монголын Чингис хаанд хүрч ирэхүйн цагт сая эртний Монголын нутаг цөм алджухуй. Эдгээр орныг авах тухай бүр нэрийг нь өөрчилсөн нь эдүгээ Хөх нуур ба Ирхайн хязгаарыг Ганьсу муж, Хэси хэмээх баруун мужийг Шэньси муж, Хэдун хэмээх зүүн мужийг Шаньси муж, Хунань хэмээх өмнө мужийг Ху нань муж, Хубай хэмээх хойд мужийг Дили муж, эдүгээ бас Хэбэй муж хэмээмүй. Ляодун хэмээх зүүн мужийг Мүгдэн муж, Ляо си хэмээх баруун мужийг Гиран муж хэмээсэн нь одоо Ганьсу, Шэньси, Шаньси, Хэбэй, Хэнань мужууд нанхиадын дундат улсад буй амой. Мүгдэн, Гирин гэх мужууд манж Го улсад буй амой. Энэ нь эртний монгол нутаг газар болох тул эх түүхэнд чухал холбогдох учир ийнхүү цухас тэмдэглэв. Үүнээс урагш Чингис хаанаас эхлэн Их Юань улсын эцсийн үед хүртэл Ази тивийн бүх газар цөм Монголын хаан эзний болсон тул, Монголын нутаг орон хэмээн ялгаварлан хэмэлцэх зүйл үгүй болой.

Монголын Их Юань улс эцсийн үеэс Монголчууд 4 хэсэг тусгай улс болж нэгэн залгаа газар оронд тус тус нутаглан суусан нь: 1.Чахар улс, 2.Халх улс, 3.Чичигар улс, 4.Зүүнгар улс хэмээх Өөлд улс болмой.

Үүнд манжийн Дайчин (Их Чин) улсын эхний үед Чичигар улс дайчин улсад дагаар орж уг газраас дотогш нүүдэллэж Чичигар улсын газрыг Хар мөрөн муж болгож манж нарыг шилжүүлгэн суулгаж одоо хэвээр Манж Го улсад буй амой. Чахар болон түүний харъяаны Хөх хотны Түмэд аймгийг Дайчин улс байлдан сөнөөж цөмийг нь эзлэн авсан нь одоо Чахар муж болой. Энэ нь Сүй юань муж болсон амой. Зүүнгар хэмээх Өөлд улсын Галдан бошигт ханаас эхлэн Амарсанаа хан хүртэл Дайчин улс байлдан сөнөөж Или хязгаарын орныг эзлэн авч, манжийн

Дайчин улсын шинэ хязгаар хэмээн нэгэн муж болгосон нь одоо хэвээр буй амой. Үүнээс дээш Монголын газар орныг нэгэнт алдсаныг цухас тэмдэглэснээс гадна, дайчин улсын үед Монголыг 3 хэсэг болгосон нь Өвөр Монгол, Ар монгол, Баруун монгол хэмээмэй.

Бүх газрын хязгаар нь зүүн этгээд Манжийн 3 мужид зах зэрэгцсэн. Өмнө этгээдэд Нанхиадын дундад улсын Дили хэмээх Хэбэй, Шэньси, Шаньси, Ганьсу 4 мужид зах нийлмэй. Баруун этгээдийн Дайчин улсын шинэ хязгаарт залгамжилсан, Умард этгээдийн Орос улсын Сибирийн Байгал муж Эрхүү хот, Томск хотод зах нийлмэй. Үүний дотор Өвөр Монголын умард хязгаар нь эдүгээгийн БНМАУ-ын зүүн өмнөөс баруун өмнө хүртэл зах нийлмэй. Баруун Монгол хэмээх дээд монголын зүүн хойд ба хойд хязгаар нь мөн БНМАУ-ын баруун өмнө хүртэл зах нийлмэй.

Өвөр Монголын нутаг газар нь 6 чуулган, 49 засаг хошууны орон нутаг болох бөгөөд хэрхэн хувиарлан суулгасныг дурьдваас:

1. **Жирэм чуулган** арван хошууны нутаг. Энэ газар эртний мянгаад жилийн өмнө байсан Хятан хэмээх Ляо улсын үед байгуулагдсан Шаньду хот, Монголын Их Юань улсын хаадын халуунаас зайлах орд байсан амуй. Урьд мал үржүүлэх нүүдлийн момнголчууд байсан. Эдүгээ Хятад иргэн тариалан үйлдэж Хятадын засаг захиргааны Цжоу, Сяньд шияньд захирагдаж Монгол хэмээх нэрийн төдий болсон амуй.

2. **Зостын чуулган**. Таван хошууны нутаг. Энэ газарт мянган зургаан жилийн өмнө нанхиадын Их Тан улсын хааны халуунаас зайлах орд, мянгаад жилийн өмнө Ляо улсын дундад нийслэл хот, Манжийн Дайчин улсын хааны халуунаас зайлах орд байсан амуй. Аж төрөх байдал мөн Жирэмийн чуулганы адил амуй.

3. **Зуу-удын чуулган**. 11 хошууны нутаг. Энэ газарт мянгаад жилийн өмнө Ляо улсын Шанжин мужийн захиргаа, олон цжоу сяний захиргаа байсан амуй. Урьд Хятан улс мандсан газар амуй. Аж төрөх байдал мөн Зостын чуулганы адил болой.

4. **Шилийн голын чуулган**. 10 хошууны нутаг 1000-д жилийн өмнө Ляо улсын Чжин цжоу муж, Их Юань улсын Чжан лу муж, Тогоонтөмөр хаан зайлж ирээд хальсан хот мөн. Энэ чуулганы нутаг давс, загасын ашиг олдог. Тариаланд

тохирох нь сайнгүй тул Хятадын тариалан үгүй цөм Монголчууд мал үржүүлэх, ан агнах зэргээр аж төрөх бөгөөд эртний нүүдлийн байдалд буй.

5. **Улаанцавын чуулган**, 6 хошууны нутаг. Энэ газар 2200 жилийн өмнө Нанхиадын Цинь улсын Хюань У Юань гэх цэргийн цайз байсан. 800 жилийн өмнө Алтан улсын Жүн Ни Дун муж, жич Ван хү аймгийн нутагласан газар амуй. Энэ чуулганы нутгийн ард нүүдэлийн байдалтай, мал үржүүлэхээр аж төрмүй. Эрт үед бага сага албан цэргийн тариалан байсан бөгөөд Дайчин улсын үед хятадыг оруулж тариалан тарьсан нь нилээд газрыг эзэлсэн боловч хараахан Хятадын захиргаа байгуулагдаагүй. Зарим нэг газарт монголчууд лугаа холилдон сууж Монголын захиргаанд захирагдах болой.

6. **Их зуугийн чуулган**. 7 хошууны нутаг. Энэ газар 2400 жилийн өмнө Хүн аймгийн нэг вангийн газар, 2000-д жилийн өмнө Монголын Хүннү улсын Хэнан вангийн нутаг, Их Юань улсын үед Шу ван Жун хэмээх албан захиргааны газар, Манжийн Дайчин улсын үед Монголын Чингисийн бумбыг харгалзан Ордосын 7 хошууны ард нутагласан газар амуй. Газар орны байдал Хатаны гол, Цагаан тохой хэмээх бага муруйг эзэлсэн тул мал нутаглах, тариалан тарихад цөм нийлэлцэнэ. Эртний цагт нүүдлийн байдалтай мал үржүүлэхээр аж төрмөй. Бага сага албан цэргийн тариалан буй авч монголчууд хуучин хэвээр байсан амуй.

Хожим Дайчин улсын сүүлийн үед Хятадыг үлэмж олноор оруулж, тариалан тариулж газар орныг ихээхэн эзэлж, Хятадын захиргаа байгуулсан учирт, монголчуудын зарим нь тариалангийн ажилд орсон боловч их төлөв нь хуучин хэвээр байсан амуй.

7. **Хөх нуурын баруун Монгол**. **Олон аймаг** чуулгангүй 29-н хошууны нутаг энэ газар 4000-н жилийн өмнө баруун зүгийн нутаг, Монголын Хүннү улсын үед Си хай вангийн газар, 1700-д жилийн өмнө Сүй улсын Ху Юань хэмээх дарангуйлан суух цэргийн 2 цайз, 1500 жилийн өмнө Сяньби улсын Ту ху хунь аймгийн газар, дараа зуугаад жил болж Түвэдийн харъяат болсон 500 жилийн өмнө Монгол Ибол аймгийн газар, 300 жилийн өмнө Чингис хааны дүү Хавт Хасарын угсааны Гүүш хааны газар, Хөх нуурт загас, давсны ашиг их, ургац богино, мал үржүүлэх хугацааны нүүдлийн байдал хэвээр буй. Тариалангийн хятад үгүй, хаяа нэг хятадын бага сага тариалан буй авч хятадын захиргаа үгүй, цөм Монголын захиргаанд захирагдмуй. Одоо хятадын харъяанд хэвээр буй амуй.

Үүнээс дээш тодорхойлсон Монголын газар нутаг болбоос 2 үе хуваана. Нэг нь эрт үе, хоёр нь дунд үе. Эдгээр газар орныг цөм гадаад улсад алджээ. Ар Монгол эртний халхын 3 аймаг, 7 хошууны нутаг, эдүгээ Бүгд Найрамдах Бүрэн Эрхт Монгол Ард Улсын газар нутаг мөн амуй. Үүнийг 4 чуулган, Ховд хязгаар хэмээн 5 хэсэг болгон хувааж тус тусын газар оронд хэдийд ямар аймаг улс нутаглан суусан ба тэдний хил хязгаар, газар орны байдлыг тодорхойлон тэмдэглэсэн нь:

1. **Хэрлэн барс хотын чуулган.** Дайчин улсын үед зохиогдсон Халхын сэцэн хан аймгийн 23 засаг хошууны нутаг, эдүгээгийн Дорнод, Хэнтий аймаг, Дорноговь аймгийн зүүн талын газар болмой. Энэ газарт нанхиадын Хан улсын үе бөгөөд эдүгээгээс 2200 жилийн өмнө Хүннү улсын Цо Син вангийн газар; Монголын Хятан хэмээх Ляо улсын үе бөгөөд 1000-д жилийн өмнө Ляо улсын Дун Чэн хэмээх Зүүн нийслэл, энэ хотын ор тэмдэг урьдах сан бэйсийн хүрээ эдүгээ Дорнод аймгийн төвөөс баруун зүг арав гаруй км газарт буй амуй. Зөрчидийн Алтан улсын үед Монголын Чингис хааны төрсөн ба мэндэлсэн газар мөн. Үүнээс урагш эдүгээ хүртэлх Монгол улсын хэвээр суусан нутаг мөн амуй. Хил хязгаар зүүн этгээд Эрдэнэ уул, Хар мөрөн мужийн Хөлөнбуйрт зах нийлдэг. Өмнө этгээд Торгон Чандмань, Бага Элст манханийг өнгөрч Өвөр Монголын Шилийн голын чуулганы хуучид, Авга, Авганарын засаг хошуудад зах нийлдэг. Баруун этгээдийн Улаан чулуут умар этгээд Орос улсын Байгал мужид зах нийлмой. (Эдүгээгийн СССР зүүн Сибирь муж) Зүүн өмнө этгээд Шилийн голын чуулганы Үзэмчиний засаг хошуунд зах нийлдэг. Баруун өмнө Түшээт хан аймагт зах нийлдэг. Орон нутгийн байдал, Хэнтий уулын маш өндөр Бурхан Халдун уулын судал зүг Хэрлэн Баян Улаан ууланд хүрмүй. Өмнө этгээд болбоос цөм төвшин тал. Энэ уулын баруунаас гарсан Туул гол, өмнөөс гарсан Хэргэн гол, зүүнээс гарсан Онон гол, гурван их голын эх болмой. Онон голын Болдог Дэлүүн толгойн газар Чингис хаан төрсөн амуй. Эртний Ляо улсын үед бага сага албан цэргийн тариалан байсан авч Чингис хаанаас инагш эдүгээ хүртэл тариалангийн газар үгүй болой.

2. **Хан уулын чуулган.** Дайчин улсын үед зохиогдсон халхын Түшээт хан аймгийн 20 засаг хошууны нутаг эдүгээгийн Төв аймаг, Сэлэнгэ аймаг, Дорноговь аймгийн баруун тал, Өмнөговь аймгийн зүүн талын нутаг мөн амуй. Энэ газарт эдүгээгээс 2000-д жилийн өмнө Монголын Хүннү улсын нэгэн хаан суусан газар, 1800-д жилийн өмнө Монголын Тоба Юань Вэй улсын баруун нэг аймгийн газар,

1600 жилийн өмнө Түрэг улсын үед Хүй хэ-ийн Түн лу аймгийн нутаг, 1000д жилийн өмнө Ляо улсын Зэн Эю мужийн газар, 800-д жилийн өмнө Алтан улсын үед Ван хааны халууныг зайлах орд (энэ хаан суусан учирт Хаан Уул хэмээн нэрийдсэн амуй. Энэ нь эдүгээгийн Улаанбаатар хотын өмнө Богд уул мөн), Чингис хаанаас инагш Монголын Их Юань улсын үед уулын умард хязгаарын Сан Жүн Шань мужийн газар, үүнээс урагш эдүгээ хүртэл Монгол улсын хэвээр суусан нутаг мөн амуй. Хил хязгаар нь зүүн этгээд Хэнтий уул, Сэцэн хан аймагт зах нийлнэ. Өмнө этгээд их элсэн говьд хүрнэ. Баруун этгээд Онгийн гол, Орос улсын Байгал муж лугаа зах нийлнэ. Зүүн өмнө этгээд говийг өнгөрч Өвөр Монголын Шилийн голын чуулганы зүүн, баруун Сөнөдийн 2 аймаг засаг хошуу, Улаанцавын чуулганы Дөрвөн хүүхэд, тарган бэйлийн хоёр засаг хошуунд зах нийлнэ. Баруун хойд этгээд Тагна урианхайд зах нийлмой. (Энэ нь Эдүгээн Тува улс мөн) Хангай ууланд түшсэн Хан уулын дундад цухуйн зогсжээ. Туул голын уулын ар хормойгоор баруун зүг урсаж зүүн хойд зүг муруйн дугуйлж, Хараа гол, Зүрх гол, Орхон голд нийлж Сэлэнгэ голд нийлээд Орос улсын Байгал бялхмалд хүрмой. Өмнөговийн дотор Цэцэг уул ганцаар өндөр цухуймой. Туул голын умард этгээд эдүгээгээс 200 жилийн өмнө байгуулсан Жибзундамба хутагтын хүрээ, дараагаар Дайчин улсын манж амбаны суусан яамны газар (эдүгээн Улаанбаатар хот) энэ аймгийн хойд этгээдэд албан ба монгол, хятад ардын тариалан буй бөгөөд сүүлийн үед цөм хятадын тариалан болсон нь эдүгээ ч нилээд баймой. Умард хязгаарт Хиагт хэмээх Орост нэвтрүүлэх албаны худалдааны газар байгуулж, иргэдийг захирах Дайчин улсын заргач түшмэл суусан, Наймаачин хэмээх хот буй (Эдүгээн Алтанбулаг мөн) амуй.

3. **Цэцэрлэгийн чуулган.** Дайчин улсын үед зохиогдсон Халхын Сайн ноён аймгийн 24 хошууны нутаг, эдүгээ Өвөр, Архангай аймаг, Өмнөговь аймгийн Баруун тал, Завхан аймгийн зүүн тал газар. Энэ нь эртний Монголын Няньхин хэмээх Яркай хотын хязгаарын гадна элсэн манхны умард газарт буй амуй. Эдүгээгээс өмнө 2200 жилийн өмнө Хүннү улсын хаан суусан газар, 1600 жилийн өмнө Түрэг улс, Хотон улсын хаан удаа дараагаар суусан газар, Монголын Их Юань улсын Мөнх зэрэг 4 хааны урьд хожид нийсэллэж суусан газар, эдүгээн Эрдэнэзуу зэрэг газар мөн. Их Юань улсын Хубилай хаанаас инагш давааны умард Чжин Жүншу Чжен муж газар, хил хязгаар нь зүүн бор бургас олом, Түшээт хан аймгийн зах лугаа нийлсэн өмнө этгээд элсэн манханыг өнгөрч Өвөр

Монголын Улаанцавын урд Алашаагийн засаг хошууны нутаг Эзний зэрэг аймгийн зах лугаа нийлдэг. Баруун этгээд Хүн сан бүгд, Эзэн даваа, хойд этгээд Үтэр гол, Засагт хан аймаг лугаа зах нийлнэ. Зүүн хойд этгээд Тагна Урианхайд хүрдэг. Газар орны байдал Алтай, Хангай, Тагна гурван уулын судал нийлсэн газар. Сэлэнгэ гол, Орхон гол, Завхан голын зэрэг эх гарсан газар. Энэ аймгийн уул, гол маш сайхан элсэн говийн умард тэргүүн зэргийн нутаг болно. Тийний гайхамшигт мөр болбоос Хүннү улсын зэрэг олон хаадын орд харшийн газар болох учир болой. Орхон Цайдам, Байдраг зэрэг газарт дурсгалт хөшөө чулуу буй амуй. Энэ аймгийн баруунд эдүгээгээс 200 жилийн өмнө байгуулагдсан Улиастай хот (эдүгээ Жавхлант хот, Завхан аймгийн төв мөн) Дайчин улсын үед манжийн хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслах жанжин сууж Халх Монголын хэргийг ерөнхийлөн захирмой. Энэ аймгийн нутагт эрт цагт бага сага албан цэргийн тариалан байсан амуй. Эдүгээ ч Монголчуудын хувийн бага сага тариалан буй амуй.

4. **Биньдэрьяа нуурын чуулган.** Дайчин улсын үед зохиогдсон Засагт хан аймгийн 10 хошуу нутаг. (эдүгээ Завхан, Ховд аймаг) Энэ газарт эдүгээгээс 2000-аад жилийн өмнө Хүннү улсын Нү Сиян вангийн газар, 1800 жилийн өмнө Сяньби улсын баруун газар, 1000-д жилийн өмнө Хар Кидан хэмээх Баруун Ляо улсын газар, 800 жилийн өмнө Найман улсын өмнөд аймгийн газар, Чингис хаанаас янагш Монгол Улсын баруун аймгийн нутаг, хил хязгаар нь зүүн этгээд Онгийн Халиуд, Сайн ноён хан аймаг лугаа зах нийлнэ. Өмнө этгээд Алтайн Хар толгой, Их элсэн манханыг өнгөрч эдний аймаг, Илийн хязгаарт зах нийлдэг. Баруун • этгээд Хар ус, Төгрөг нуур, Ховдын хязгаарт зах нийлнэ. Хойд этгээд Итгэл гол, Ховд хязгаарын Тагна уул, Тагна Урианхай (эдүгээгийн Тува улс мөн)-д зах нийлдэг. Газар орны байдал, умарт этгээд шугуй үлэмж, өмнө этгээдэд булаг, нуур үлэмж, эртнээс инагш нүүдлийн аймгийн мал адгуулах бэлчээрийн газар, Дайчин улсын үед бага сага албан тариалан тарьж байсан бөгөөд хожим орхигдсоныг Монголчууд бага сага тариалан тарьж агсан нь одоо ч зарим газар хэвээр буй амуй.

5. Ховд хязгаар. Алтайн өөлдийн 7 аймаг, 21 хошууны нутаг Өөлдийн дөрвөд, Хорид аймг 14 хошуу, **Сайн Заяат чуулган** хэмээмой. Өөлдийн Торгууд 1 аймаг, 2 хошуу, Өөлдийн хошууд 1 аймаг, 1 хошуу, Захчин аймаг 1 хошуу, Мянгад аймаг 1 хошуу, Урианхай аймаг 2 хошуу болмуй. Эд цөм Өөлдийн Галдан бошогт

хааны харъяат хүмүүс бөгөөд эдүгээгээс өмнө 200 жилийн үед Дайчин улсад дагаар орох буюу олзлогдож хошуу сум зохиож Ховдын хязгаарын газарт шийтгэн суулгаж манж хааны хуувийн сайд томилон Ховд хот (эдүгээгийн Жаргалант хот)-д түшмэл цэргийн хамт суулгаж захируулжээ. Энэ газарт эдүгээгээс 1800 жилийн өмнө Түрэг улсын газар, 1000- жилийн өмнө баруун Ляо хэмээх Хар Кидан улсын хааны суусан газар, 800-гаад жилийн үед Монголын Найман аймаг улсын Тиян хааны суусан газар, Чингис хааны үед Монгол улсын баруун аймгийн нутаг, 300-аад жилийн үед Өөлд улсын Галдан бошигт хааны суусан газар, 250-аад жилийн үед Галдан бошогт хаан, Манжийн хаан хоёр дайн байлдаан бололцож, Галдан бошогт хаан дарагдаж эдгээр газар орныг Дайчин улс олзлон авч хот байгуулж сайд түшмэд цэргийг томилон суулгаж Ховдын хязгаар хэмээн нэрийджээ. Энэ хязгаарт газрын хөрс шим нь сайн бөгөөд дулаан болох учирт эртнээс янагш албан цэргийн тариаланг ихээхэн тарьж байсан ба Дайчин улсын үед Хар усны тариалан хэмээх Буянт голд арвин газрын албан цэргийн тариа тарьсан нь эдүгээ хэвээр буй. Бас Улаангомын зэрэг газарт урьд албан цэргийн тариалан байсан нь одоо монголчууд зарим газар баг сага тариа тарина. Хил хязгаар нь зүүн этгээд Халхын Засагт хан аймаг, өмнө этгээд манжийн шинэ хязгаар хэмээх Илийн хязгаар, Баруун этгээд Ил тарвагатайн тинхим, хойд этгээд Тагна Урианхай, Баруун хойд этгээд Орос улсын Томск муж, Семипалатинск мужид захууд нийлдэг. Газар орны байдал: Баруун хойд этгээд маш өндөр уул, Алтай Тагна ууланд залгагдсан Ховд гол, Хар ус нуурт ордог. Тэс гол Увс нуурт ордог. Бүрэн хан гол урсаж, Хүйс болон Хэсэрбиш нуурт ордог. Эрчис голын эх Алтайгаас гарчээ. Хойд этгээдийн мод шугуй үлэмж. Араатан гөрөөс элбэг. Өмнө этгээд Хангай хэмээх говь хүртэл булаг худаг цөөхөнгүй буй амуй.

Худам монгол бичгээс кирилл үсэгт буулгасан
түүхч Хэрээд Ж.Урангуа